



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар АНЗ

Мандалговь

“Гэр бүлийн өдрийг гэр бүлдээ” нөлөөллийн
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйл, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.55 дах заалт, Дундговь аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлийн 2.3.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хөл хорионы хугацаанд цахимаар дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлээрээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх дадал, хэвшилд уриалах, үр хүүхдээ хөдөлмөрч шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж буй гэр бүлийг олон нийтэд сурталчилах зорилгоор “Гэр бүлийн өдрийг гэр бүлдээ” нөлөөллийн арга хэмжээг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. “Гэр бүлийн өдрийг гэр бүлдээ” нөлөөллийн арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1534000 (Нэг сая таван зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

487190087

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын
11-ны өдрийн 143 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



**"ГЭР БҮЛИЙН ӨДРИЙГ ГЭР БҮЛДЭЭ"
НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Зорилго:

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олон нийтэд сурталчлах, Олон Улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хөл хорионы хугацаанд цахимаар дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлээрээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх дадал, хэвшилд уриалах, хүүхэд хүмүүжлийн эерэг хандлагыг түгээхэд оршино.

Санаачлагч байгууллага: Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Зохион байгуулагч: Сумдын засаг даргын тамгын газар, байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүд

Хамрах хүрээ: Дундговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучууд

Хугацаа: 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл

Зохион байгуулагдах арга хэмжээний чиглэл:

"Нэг гэр бүл-Нэг дурсамж" цахим уралдаан:

Өрх гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, гэр бүлээрээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, гэр бүлээрээ аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бусдыгаа зөв дадал зуршилд уриалах ажлыг зохион байгуулах, цахим пэйжээр дамжуулан гэр бүлүүдийг сурталчлах

Аймгийн "Шилдэг гэр бүл" шалгаруулах уралдаан:

Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдарлын утга учир, эцэг эхийн үүрэг хариуцлагыг таниулах, үр хүүхдээ хөдөлмөрч шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж буй гэр бүлийг олон нийтэд сурталчилах, "Шилдэг гэр бүл"-ийг шалгаруулах

"Гэр бүлийн боловсрол олгох чиглээрх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах:

Гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцааны тогтвортой байдлыг дэмжих, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох чиглэлийн 4 төрлийн цахим сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Үүнд:

- 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10.00 цагт, "Сэтгэл зүйн боловсрол-эцэг эхийн оролцоо", "Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй-эцэг эхийн дэмжлэг"
- 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 13.00 цагт, "Сэтгэл зүйн цаг агаар"
- 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 11.00 цагт "EQ-тэй гэр бүл" сэдэвт сургалтууд тус тус зохион байгуулагдах тул байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүд, гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийг хамруулах.
- Сургалт Zoom аппликэйшнээр зохион байгуулагдана.


"Миний гэр бүл-Аюулгүй орчин" орон гэрийн аюулгүй байдлыг үнэлэх:

Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор "Миний гэр- Аюулгүй орчин" хяналтын хуудсаар гэр бүлийн орчин нөхцөлд үнэлгээ хийж хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг уриалж, олон нийтийн цахим сүлжээнд давлагаа өрнүүлж, түгээж ажиллах.

Сумдууд гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 18 өрхөд, эцэг эхийн зөвлөлүүд байгууллагынхаа ажилтан, албан хаагчийн гэр бүлд "Миний гэр-Аюулгүй орчин" хяналтын хуудсаар үнэлгээ хийж, үнэлгээний дагуу гарсан зөрчлийн илрүүлж, арилгах арга хэмжээг зохион байгуулах /"Миний гэр-Аюулгүй орчин" үнэлгээний хуудсыг "Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар" пэйж хуудаснаас татаж авах/

----oOo----

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын даргын 2021 оны 5 дугаар сарын
11. ны өдрийн 115 тоот тушаалын 92 дугаар хавсралт



**"ГЭР БҮЛИЙН ӨДРИЙГ ГЭР БҮЛДЭЭ" НӨЛӨӨЛЛИЙН
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Аймгийн "Шилдэг гэр бүл" шалгаруулах үйл ажиллагаа					
1	Энгэрийн тууз	ш	12000	9	108000
2	Өргөмжлөл	ш	90000	9	810000
"Гэр бүлийн боловсролыг олгох сургалт" нөлөөллийн үйл ажиллагаа					
4	Сургалтын зардал /Багш, гэр бүл судлаач Б.Бурмаа/	цаг	40000	8 цаг 30 минут	340000
"Нэг гэр бүл-нэг дурсамж" цахим уралдаан					
5	Мөнгөн шагнал 1-р байр	Шагналт байр	100000	1	100000
6	Мөнгөн шагнал 2-р байр	Шагналт байр	80000	1	80000
7	Мөнгөн шагнал 3-р байр	Шагналт байр	60000	1	60000
8	Өргөмжлөл	ш	12.000	3	36000
Нийт					1534000

----oOo----